

# **2020 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ**

## НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ

### БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН БАГШ НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ “БАГШ-2020” СПОРТЫН 4 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд зохион байгуулагддаг спортын 4 төрөлт тэмцээн 2020 оны 01-р сарын 6-10-ны хооронд 33, 48, Шавь цогцолбор, Шинэ монголын сургуулийн зааланд амжилттай явагддаж өндөрлөлөө. Тэмцээнийг дүүргийн боловсролын хэлтэс, биеийн тамир спортын хороо хамтран зохион байгуулж явуулсан. Тэмцээнд нийт 28 сургуулийн 900 гаруй багш нар хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс:

#### Сагсан бөмбөг

##### ЭРЭГТЭЙ

- 1-р байр 33-р сургууль
- 2-р байр 48-р сургууль
- 3-р байр 102-р сургууль

**Шилдэг тоглолч:** 48-р сургуулийн багш Билгүүн /эрэгтэй/ , 84-р сургуулийн багш Отгонжаргал /эмэгтэй/

##### ЭМЭГТЭЙ

- 1-р байр 84-р сургууль
- 2-р байр 33-р сургууль
- 3-р байр 44-р сургууль

#### Волейбол

##### ЭРЭГТЭЙ

- 1-р байр 84-р сургууль
- 2-р байр 55-р сургууль
- 3-р байр 48-р сургууль

**Шилдэг тоглолч:** 48-р сургуулийн багш Мөнх-Алдар /эрэгтэй / , 55-р сургуулийн багш Отгонцэцэг / эмэгтэй /

##### ЭМЭГТЭЙ

- 1-р байр 55-р сургууль
- 2-р байр 133-р сургууль
- 3-р байр 92-р сургууль

#### Олс

- 1-р байр Шавь цогцолбор сургууль
- 2-р байр 97-р сургууль
- 3-р байр Шинэ монгол сургууль

#### Шатар

- 1-р байр И3 сургууль
- 2-р байр Шинэ монгол сургууль
- 3-р байр 92-р сургууль

Багийн нийлбэр дүнгээр 84-р сургуулийн хамт олон тэргүүлж өргөмжлөл, мөнгөн шагнал, шилжин явах цомын эзэд болж дэд байранд 44-р сургууль, гутгаар байранд Шинэ монгол сургуулийн хамт олон шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “ИРГЭДИЙН СПОРТЫН IX НААДАМ” ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын IX наадам”-ын дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10 дугаар сарын 31-ээс 2020 оны 11 дүгээр сарын 8-ний хооронд олс таталт, софт волейбол, волейбол гэсэн спортын 3 төрлөөр давхартсан тоогоор 16 хорооны 573 тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шалгарсан багууд нийслэлийн иргэдийн наадамд оролцох эрхээ авлаа.



### “Спорт-эв нэгдэл- ковид-19” сэдэвт гар зургийн уралдаан

Тамирчдын баярын өдрийг тохиолдуулан Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд Шинэ короно вирус /Ковид-19/ цар тахлын халдварын үед сурагчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, спортын ач холбогдолыг сурталчилах, олон нийтэд таниулах, оролцогчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гар зургийн уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулагдлаа. 2020 оны 05/15-06/20 хооронд зохион байгуулагдсан гар зургийн уралдаанд нийт 28 бүтээл ирүүлж нас болгонд шалгарсан хүүхдүүдийг өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.

### “Сурагчдын биебялдрын хүмүүжил-олимпийн боловсрол-ковед-19” сэдэвт Биеийн тамирын багш нарын цахим илтгэлийн уралдаан

ЕБД сургуулиудийн Биеийн тамирын багш нарын дунд 2020 оны 05/15-06/20 хооронд зохион байгуулагдсан цахим илтгэлийн уралдаанд 11 байгууллагын 12 багшийн ирүүлсэн материалуудыг шалгарууласнаас:

- 1-р байр 48-р сургуулийн Биеийн тамирын багш Э.Гэрэлтуяа
- 2-р байр 87-р сургуулийн Биеийн тамирын багш Э. Гэрэлмаа
- 3-р байр ШЦСургуулийн Биеийн тамирын багш Ц.Анхбаяр
- 4-р байр 97-р сургуулийн Биеийн тамирын багш Отгонцэрэн нар тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.





Д  
Дүүргийн хэмжээнд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмолжуулан иргэд, ажилтан албан хаагчдын бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлж хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг улам сайжруулж, тэднийг биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөний ач холбогдол, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран дүүргийн харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагчдын дунд ажлын байрны сургалтыг зохион байгуулж ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус байгууллагууд мөн ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачлагаар зохион байгуулж байгаа нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол хүргэж хэвшсэн.

Нийслэлийн Засаг дарга болон Нийслэлийн спорт хорооноос үүрэг чиглэл болгосноор Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран Ковед-19 -н эсрэг иргэдийн эрүүл мэндийг дэмжиж, дархлаажуулах "Эрүүл мэндийн өглөөний дасгал" -р хичээллэх аяныг амжилттай хэрэгжүүллээ.

Тус цогц дасгалыг зохиогч Х.Энхтуяа багш, Спорт хариуцсан мэргэжилтэн Б.Самбууням нар заан хичээллүүлж байгаа ба дүүргийн 30-40 иргэн өглөө бүр 07:00 цагаас ҮЦХ-гийн "Цагдаагийн талбай"-д хүрэлцэн ирж өглөөний дасгалаа хийж хэвшээд байна. Энэхүү арга хэмжээний тухай Монголын үндэсний телевизийн МНБ-сүвгаар мэдээ цацагдлаа.



### **"Дэлхийн алхалтын өдөр-2020" идэвхтэй алхалтын 10 хоногийн аян**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, COVID-19 цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжихэд зорилго оршино.

Дэлхийд жил бүрийн 10 дугаар сард “Дэлхийн алхалтын өдөр”-ийг идэвхитэй хөдөлгөөн, алхалтын ач холбогдолын талаар олон нийтэд сурталчлан, таниулах зорилгоор тэмдэглэдэг. Манай улс 2017 оноос хойш уг өдрийг уламжлал болгон тэмдэглэж иржээ. Энэ жил тус аяныг 10 дугаар сарын 21-31-ны хооронд 10 хоногийн турш Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, БТСУХ, Нийслэлийн биеийн тамир спортын хороо хамтран “Идэвхитэй алхалтын 10 хоног” уриан дор зохион байгууллаа.



Идэвхитэй алхалтын 10 хоног” -ийн аяны хүрээнд Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооноос Баянзүрх дүүргийн "Алхалтын өдөр"-ийн хөтөлбөр, төлөвлөгөө гарган батлуулж, 10-р сарын 24-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн Усан ориглуурын талбайд амжилттай зохион байгуулагдлаа.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дугуйн замаар нийт 3 км зам дагуу “Парад”-аар алхалтыг зохион байгуулж өдөр бүр алхаж эрүүл мэнддээ анхаарахыг уриаллаа. Тус өдөрлөгийн арга хэмжээнд БЗД-ийн Хэлтэс албадууд, сургууль, цэцэрлэгүүд нийт 61 байгууллагын 886 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдлаа.

Мөн тус өдөрлөгийн арга хэмжээнд Баянзүрх дүүргийн 10-р төвийн арга зүйч Б.Сансартуяа Өглөөний дасгалыг албан байгууллагуудад зааж, Алхалтын ач холбогдолын талаар сургалт, арга зүйн зөвөлгөө өглөө.





Насан туршийн боловсролын төвөөс “Алхалтын өдөр” -т зориулан флашмоб бүжгийг ирсэн нийт иргэдэд заан хамтран бүжиглэлээ.

Алхалтын ач холбогдол, Өдөрт 15 минут алхахад амьдрал эрс өөрчлөгдөнө сэдэвт гарын авлагыг Биеийн тамир спортын хорооноос 500 ширхэгийг хэвлэн гаргаж, Биеийн тамир улсын хорооны 100 ш гарын авлага боршурыг “Алхалтын өдөр”-ийн арга хэмжээн дээр иргэдэд мөн албан байгууллагуудад тараана зохион байгууллаа.

Мөн арга хэмжээнд идэвхитэй оролцсон 20 хүнийг шалгаруулж Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооноос магадлан итгэмжлэгдсэн фитнес клубд нэг сар үнэгүй хичээллэх эрхээр урамшуулсан.

Баянзүрх дүүргийн "Алхалтын өдөр"-ийн арга хэмжээнд 61 байгууллагын 886 иргэн оролцсоноос 404 иргэн идэвхитэй алхалтын 10 хоногийн аяны хугацаанд авто машинаас татгалзаж, ажилдаа ирэхдээ явганаар алхсан. Мөн албан байгууллагууд нийт 361 км зам алхаж, алхалтын өдрийг зохион байгуулсан байна.

Идэвхитэй алхалт 10 хоногийн аян хугацаанд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг 27 байгууллагаас нийт 92 хуудас тайлан ирүүллээ.

### **“Алхалт - амьдралын хэв маяг” онлайн видео уралдаан**

Дэлхийн алхалтын өдрийг тохтолдуулан “Алхалт - амьдралын хэв маяг” онлайн видео уралдаан 2020 оны 10 сарын 21-29-ны өдрүүдэд болж дүнгээ гаргалаа. Нийт 14 байгууллагаас тус уралдаанд материал ирүүлсэн ба 7 шалгуур үзүүлэлтээр дүгнэн эхний 3 байранд шалгарсан байгууллагуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

I байр 61-р цэцэрлэгийн хамт олон

II байр Шавь цогцолбор сургуулийн хамт олон

III байр 63-р цэцэрлэгийн хамт олон шалгарлаа.



## СУРГАЛТ

### “Ширээний теннисний техник, онол арга зүйн семинар

Баянзүрх Дүүргийн Биеийн Тамир Спортын Хорооноос зохион байгуулсан ширээний теннисний техник онол арга зүйн семинарыг спорт хариуцсан мэргэжилтэн О.Түмэнжаргал, спорт хариуцсан мэргэжилтэн Б.Самбууням ширээний теннисний өсвөр үеийн шигшээ багийн дасгалжуулагч Ц.Баатар нар Цагаан сүлд клуб дээр 09-р сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Сургалтанд 16 хорооны 50 хүн хамрагдлаа.



### “Иргэдийн спортын IX наадам” -ын “Хийн дасгал, аэробик” -ийн сургалт

Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын IX наадам”-ын Хийн дасгал, аэробикийн сургалтыг Нийслэлийн спортын хорооноос 2020 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр Шавь цогцолбор сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтанд дүүргийн нийт 6 хорооны 75 иргэн хамрагдлаа:



## НИЙГМИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг, Монгол улсын Засгын газрын 2020 оны 30, 39, 62, 63 дугаар тогтоол Улсын онцгой комиссын 2020 оны тогтоол, шийдвэрүүд, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/168, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын даргын 01, 02 дугаар тушаал, Нийслэлийн онцгой комиссын 2,3,4 дүгээр хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан зааварын дагуу иргэд олон нийтийг шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих, эргүүл хийх график, хуваарийг 3 сарын хугацаанд нийт 3 удаа гарган байгууллагын даргаар батлуулан хяналт тавин ажиллаа.

Урьдчилан сэргийлэх , хяналт тавих бүсчилсэн хуваарийн дагуу ажилтан албан хаагч нар эргүүлд гарч, короновирусын халдвараас сэргийлэх зөвлөмж хуудсуудыг хэвлэн тарааж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна.



Улсын онцгой комиссын 2020 оны 04 сарын 16-ний өдөр Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдлийг бууруулах “Амны хаалтаа зүүцгээе” аяныг дэмжин өрнүүлж байгууллагын нүүр ном хуудсаар дамжуулан маскаа тогтмол зүүх чөлленжид нэгдэхийг уриаллаа.

Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1016 дугаар захирамжийн хүрээнд сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт, борлуулалт, түгээлтийн байдал, түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон бүсэд авч хэрэгжүүлж байгаа ажлын хүрээнд дүүргийн шуурхай штабаас гаргасан хуваарийн дагуу байгууллагын дарга, албан хаагч нар 24 цагийн шуурхай жижүүрээр 3 удаа ажилласан. Шуурхай штабт жижүүрлэх үеэр ирсэн гомдол санал, дуудлагийг хүлээн авч зохих шатны албан хаагч болон байгууллагуудад мэдэгдэн яаралтай арга хэмжээ авах, утаагүй түлшний цэгүүдээс мэдээлэл цуглуулан ирсэн болон борлуулсан түлшний тоо хэмжээг нийслэлийн шуурхай штабт цагийн хуваарийн дагуу мэдээлэл хүргүүлэн ажиллаа.



Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай дүүргийн Засаг даргын А/449 тоот захирамжыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тандалт судалгаа авах, эргүүл хийх хуваарь гарган ажиллаж 1-р хорооны ажлын хэсгийнхэнтэй уулзан хуваариа танилцуулан нутаг дэвсгэрт хүчирхийллээс сэргийлэх зөвлөмж тараалаа.






Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 тоот тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 сарын 12-ны өдрийн А/1242 тоот захирамжын хэрэгжилтыг хангах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор байгууллагын **Спорт хороо Баянзүрх** нүүр хуудас болон бусад сошил медиа

**Спорт Хороо Баянзүрх**  
4d • 🌐  
Хариуцлагатай иргэн байя



хэрэгсэлүүдийг ашиглан  
тахлаас урьдчилан сэргийлж, гэртээ дасгалаа хийж, дархлаагаа дэмжихийг уриалж байна.



← **Чөлөөт бөхийн ба...** 🔍 ⋮

📺 Live 📷 Photo 🗣️ Room

New Activity SORT

**Batsaikhan Yungerendorj Mgl** was live. 1h • 📷

Бөхийн барилдааны үйлдэл ба мэхэнд өгөх үнэлгээ – with Dandar Jamsran and 8 others.

Дэлгэц бөхийн үйлдэл эргэлдэгч нь жил болон давжанаас барилдаж эхэлжээ тэтгэлэх, хэрсонтой үйлдэл өгөх, эсвэл буудал авирлавал (Чөлөөт барилдаанд)

📺 WORLD WRESTLING

👍❤️🔥 21 27 Comments • 51 Views • Seen by 🌐🌐🌐

хөл хорионы үед Ковидоос өөрийгөө болон бусдыг хамгаалах, дархлаагаа дэмжиж дасгалаар хичээллэх талаар зөвлөгөө, уриалга нийтэлж гэрийн нөхцөлд хийх дасгал хөдөлгөөнийг нийтэд сурталчлах талаар арга хэмжээ авч ажиллаа. 2020оны 11 сарын 11-ээс эхэлсэн сошил арга хэмжээний хүрээнд нийт 13 пост оруулж 1467 хандалт аваад байна. Мөн өндөржүүлсэн бэлэн байдлын үед биеийн тамир спортын талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дасгал хөдөлгөөн сурах болон зарим төрлийн спортын багш дасгалжуулагч нарт сургалт зохион байгуулан ажиллаа.

**Спорт Хороо Баянзүрх**  
6т • 🌐


COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлж, гэртээ тогтмол дасгал хөдөлгөөн хийж, дархлаагаа дэмжээрэй.  
Дасгал хоорондын амралт 1-2 минут.

Ганд асууж лавлах шаардлагатай зүйлс байвал манай 1900-1063 дугаарт холбогдоорой.... See More

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ  
Иргэн Таны асуултанд хариулах

Call center  
**1900 1063**  
төв ажиллаж байна.

**ТА ЗАЛГА БИД ХАРИУЛЪЯ**



Дүүргийн Засаг даргын 2020 оны 11 сарын 03 өдрийн албан бичгийн дагуу Маскаа зүүцгээ 2-р аянд нэгдэж байгууллагын хүрээнд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулж, халдвар хамгааллын дэглэмийг тогтмол сахин хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг хугацаанд нь тогтмол хүргүүллээ. Мөн тус аянд нэгдэхийг уриалсан зөвлөмж, уриалгыг байгууллагын мэдэллийн хэрэгсэлээр явууллаа.

## СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

### Баянзүрх дүүргийн өсвөр үеийн Үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн өсвөр үеийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10-р сарын 24 -нд 102-р сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд нийт өсвөрийн 12 байгууллагын 50 гаруй тамирчин оролцосноос: Шагналт байранд :

#### 16 нас

I байр Т.Баатарсүх АЦС

II байр Э.Пүрэвдорж ХСИС

III байр Э.Жавхлан 48-р сургууль, З.Анхбаяр 33-р сургууль

#### 17 нас:

I байр Н.Амгаланбаатар 48-р сургууль

II байр Б.Ренчинжүгдэр 102-р сургууль

III байр Т.Түвдэндорж АЦС, Б.Жавхалантөгс 33-р сургууль

#### 18 нас:

I байр М.Бердаулет 48-р сургууль

II байр Б.Амарбаясгалан 48-р сургууль

III байр Д.Өнөболд, Р. Алтансүх 92-р сургууль нар эхний байруудыг эзэллээ.

#### Багийн дүнгээр:

I байр: 48-р сургууль- Баасанжав багштай

II байр: 102-р сургууль- М.Амаржаргал багштай

III байр: Амгалан цогцолбор Д.Гал-Эрдэнэ багштай тус тус эзлэв.





## Баянзүрх дүүргийн өсвөр үеийн Ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн өсвөр үеийн ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10-р сарын 24 -нд Ширээний теннисний “Хурд” клубын спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндрөллөө. Тэмцээнд нийт өсвөрийн 18 байгууллагын 85 тамирчин оролцлоо. Шагналт байранд багийн дүнгээр :

1-р байр 44-р сургууль

2-р байр Хурд клуб

3-р байр Эйм ай ю сургууль орлоо



## Баянзүрх дүүргийн ахмадын Ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн Ширээний теннисний ахмадын аварга шалгаруулах тэмцээн 09-р сарын 30 нд Цагаан сүлд Ширээний теннисны клуб дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 16 хорооны 45 тамирчин авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

50-59 нас

Эрэгтэй

1-р байр Д.Эрдэнэбат  
2-р байр Х.Жаргалсайхан  
3-р байр Г.Ганбаатар

эмэгтэй

1-р байр Г.Нямсүрэн  
2-р байр С.Цэцэгмаа  
3-р байр Г.Цэцэгмаа

60-аас дээш нас

Эрэгтэй

1-р байр Б.Будсүрэн  
2-р байр А.Баасанхүү  
3-р байр Д.Хосбаяр

эмэгтэй

1-р байр Л.Цогзолмаа  
2-р байр Т.Намжилмаа  
3-р байр Д.Эрдэнэчимэг



## Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” Сагсанбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн



-2019-2020 оны хичээлийн жилийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдсан “Улаанбаатар лиг” Сагсан бөмбөгийн U-10 насны ангилалын аварга шалгаруулах тэмцээн Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгч Б. Сүхбатын санаачилгаар 44-р сургуулийн багш спортын мастер Я. Эрдэнэдолгорын нэрэмжит болгон 2019 оны 12-р сарын 14 –аас 12-р сарын 15 ны өдрүүдэд 48, 53-р сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд эрэгтэй 16 багийн 192 тамирчин, эмэгтэй 7 багийн 84 тамирчин нийт 276 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээний шилдэг тоглогчоор 133-р сургуулийн О. Алтан шагай, 44-р сургуулийн Б.Хүслэн-Од, шилдэг багшаар Амгалан цогцолбор сургуулийн багш Пүрэвбат, 33-р сургуулийн багш Отгонзаяа нар шалгарч өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагддаг “Улаанбаатар лиг” Сагсан бөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 12-р сарын 14-26-ны өдрүүдэд Бага нас, Дунд нас, Ахлах насны ангилалаар 44, 53, 14, 33, Шавь цогцолбор, Амгалан цогцолбор сургуулиудын зааланд тус, тус амжилттай явагдаж өндөрлөлөө. Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 29 сургуулийн 110 багийн 1320 сурагчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. 3 насны ангилал тус бүрийн 1,2 дугаар байранд орсон багууд Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.



Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагддаг “Улаанбаатар лиг” волейболын дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 12-р сарын 27-29-ны өдрүүдэд Бага нас, Ахлах насны ангилалаар 84, Шавь цогцолбор сургуулиудын зааланд тус, тус амжилттай явагдаж өндөрлөлөө. Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 24 сургуулийн 62 багийн 744 сурагчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. 2 насны ангилал тус бүрийн 1,2 дугаар байранд орсон багууд Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.



Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдаж буй арвандөрөв дэх удаагийн “**Дуулиан-2020**” **футзалны** аварга шалгаруулах тэмцээний 2-р шат болох Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 12-р сарын 26-наас 2020 оны 01-р сарын 04-ны өдрүүдэд 102, 127, ESM сургуулийн зааланд амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд охид, хөвгүүдийн 8 насны ангилалд 74 багийн 888 сурагчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Энэ жилийн тэмцээн "БИД ДУУЛИАНЫ ЭЗЭД" уриан дор Баянзүрх дүүргийн амжилтын эзэд тодорч Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.

